

**Академич Ринчений "Миний монгол хэлээр  
орчуулсан зүйлийн  
нэр, оныг тодорхойлсон нь.  
Гагцхүү нийтлүүлснийг  
дурдвай; Чингэхдээн,  
бас, хараахан бүрэн бус" хэмээх гарбичмэл**


**Б. Сумьяабаатар**  
(ШУА)

01. Академич Ринчен багштаны эл гарбичмэл нь цорын ганц хувь бөгөөд Багштан маань, эрдэм шинжилгээний туслах ажилтан байсан надад мутраараа хүртээж хэлэхдээ: "Та, номын хүн больёо гэж бодож байгаа бол, Худгийн мэлхийн үлгэрийг байнга санаж явагтун. Хаана юу гарсныг мэдэхгүй бол сохор номин адил. Ядаж Дурсгалт бичгийн Чуулган, хүрээлэнгийнхээ цувралаар гарсан зүйлийг нэг цэгцэлчихвэл сайнсан. Улсын номын санд гарбичмэл зүйл их байгаа. Төгсгөлийн үгий нь нягталж уншваас эзэн бие нь тодордгийм. Номын санд бөгсөө хавтайтал суувал насны хоолтой болно. Дагва, Молом гэж, нүдээ аньж байгаад ч хаа юу байгааг олдог, зэргэ цолтонгуудын багш нар байгаа. Тэдэн дээр очигтун. Миний нэрийг хэлээд очсон ч болно. Гандан хийд гэж нэг номын орон буй. Та, одоохондоо шонгүй биз (*төвөөд хэл үзвэл сайн гэсэн санаа цухалзаж байв*). Хүн ер нь наандаж дэлхийн гурван хэлнээ мордчихсон байхад учиртай..." гэх мэт зөндөө сургаал айлдсан. Шинжлэх ухаан гэдэг өргөн мөрний өндөр эрэг дээр оччихоод, юу хийхээ мэдэхгүй зогсож байсан надад Багшийн хэлсэн үг нүд оруулж өгсөн.

Тэгээд улсын номын санд өдөр шөнөгүй сууж, мэдэхгүй хэл, гаргахгүй үсгийн олон арван ном, гарбичмэл үзэж, гарчиг төгсгөлийн үгийг нь хуулж байгаад нэг өдөр багшид үзүүлэхэд "Өө харла. Та тань монгол бичигтээ маруухан юмаа даа. Монгол бичгээ мэдэхгүй бол монгол хүн биш!" гэж хэлэхэд нь толгой манас, бие навтас хийгээд явчихсан. Багш ажигласан бололтой "Бас, нэг зүйлийг дагнан хийвээс ядаргаанд орно. Хэд хэдэн зүйлийг зэрэг хийвэл амралт болно. Нэгий нь эхэлж байхад, нөгөө нь дундууртаа орж, нөгөө нь дуусч байх жишээтэй" гэж хэлсэн нь миний насан турш бодож мөрдөж явдаг зүйл ээ.

Шинэ үсэг гарчихаад, монгол үсэг сургуульд заадаггүй байсан сиймхий тааралдаад, арван жил төгсөнгүүтээ гадаадад явж, харь орны хэл халтичаад ирсэн надад монгол бичгээ бие дааж сурахаас өөр зам байгаагүй. Цөхөрч шантралгүй мөлх мөлхсөөр баахан номын нэр цуглуулаад, "Монгол хэлшинжлэлийн номзүй" гэдэг нэр өгчихөөд аваачиж үзүүлтэл "Таны энд зөвхөн хэлний биш, утга соёл, ардын билиг судлалын юм ч оржээ. Нэрий нь өргөтгөөд, ном бүрийнх нь агуулгыг товч бичээд явбал Танд ч, хойч үеийнхэнд ч хэрэгтэй юм болноо доо" гэж билээ. Зөвхөн номын гарчгийг хуулах биш, юу бичсэнийг нь уншуулах гэсэн санаа байлаа. Дэлхийн дэвжээнд дэлсэн, дэн холыг харсан Багштаны энэ сургаал наддаа ахадсан зүйл байсан боловч, хичээнгүйлэн сонсч, ёсчлон дагаж, хараагаа муудтал хацраа шуумайтал суусаар "Монгол хэлний ойролцоо үгийн товч толь"(УБ.1966.191 тал), "Буриадын үгийн бичгээс" (УБ.1967.315 тал), товч тайлбар бүхүй "Монгол хэл, утгазохиол, аманзохиолын номзүй.1 Монгол хэл" (УБ.1972.364 тал), "Монгол солонгос туургаатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд" (УБ.1974.228 тал) гэдэг бүтээлээ сэрүүн тунгалагт нь хэвлүүлж тус бүр нэжгээдийг өргөн барьсан билээ, тамгат шавь нь.

Тамгат шавь хэмээсэн нь,  
Хэлзохиолын хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн 1967 оны 3 сарын 17-ны өдрийн 26/3 тоот тогтоолоор намайг академич Ринчен багштан д албан ёсоор шавь оруулсны учир бөлгөө. Тогтоолын зураг хуулбар, сийрүүлгийг толилуулбал:



БНМАУ  
Шинжлэх Ухааны Академи  
Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн  
зөвлөлийн хурлын  
ТОГТООЛ

1967 он 3 сарын 17 өдөр NO. 26/3 Улаанбаатар хот

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ЗАЛУУ Э/Ш АЖИЛТАН НАРЫН ТУХАЙ

1. Э/ш ажлыг эхлэн оролдож байгаа ажилтан нарыг ахмад эрдэмтэд доорхи хуваарь ёсоор дагалдуулан ажилуулах нь зүйтэй гэж үзсүгэй. Үүнд:

1. Ак. Б.Ринченд - Б.Сумьяабаатар
2. Ак. Ц.Дамдинмүрэнд - Д.Цэрэнсодном
3. Сурвалжлагч гишүүн П.Хорлоод - У.Загдсүрэн
4. Дэд эрдэмтэн С.Лувсанванданд - Д.Цэдэв.

2. Дагалдан ажиллаж байгаа э/ш ажилтан нар арга зүй болон бичлэгийн арга барилын талаар тогтмол зөвлөлгөө авч байвал зохино.

Захирал  
Эрдэмтэн нарийн бичгийн дарга  
гишүүд:

/ П. Хорлоо/  
/ С Лувсанвандан /  
/ Ш.Лувсанвандан /  
/ Б.Ринчен /  
/ Ц.Дамдинсүрэн /  
/ А.Лувсандэндэв /  
/ Б.Содном /  
/ Э.Вандуй /  
/ Д.Цэнд /

Одоо, Багшийнхаа гарбичмэлийн тухай үргэлжлүүлээ.

- Дээрх гарбичмэлийг цагаан шаргалдуу хавтсанд хийжээ. Хавтасны нүүрэн талын баруун дээд талд

WORLD FEDERATION OF SCIENTIFIC WORKERS

Regional Centre


PRAHA 1, Pařížská 11.

telephone 663-43

гэсэн ногоон өнгийн дардас бичигтэй.

- Орчуулсан бүтээлийнхээ жагсаалтыг 11,5x13 см хэмжээтэй зузаан шошго цааснаа хөх ба ногоон бэхээр, монгол худам үсэг болон монгол кирилл үсгээр татлан бичжээ.
- Шошго цаасны зарим нь үдээстэй, нөгөө хэсэг нь сул байв. Гэхдээ бүгд үдээсний нүхтэй.
- Миний бие эл бүртгэлийг 1965 оны 11-р сарын 3-ны Мягмар гарагийн 13 цагт ром үсгээр дэвтэрт буулгаж эхлээд, мөн оны мөнхүү сарын 30-ны 22 цаг 33 минутанд нийт 73 зүйлийг монгол кирилл үсгээр буулгасан байна. Үүнээс хойш яг дөчин жил өнгөрч, Багштаны нас сүүдэр Зууд тэгширсний их ойд зориулан ганц хувь гарбичмэлийнх нь зураг, ром үсгийн галиг, монгол кирилл үсгийн буулгалыг нийтийн хүртээл болгож байна. Багшийн маань **зуурт** тэртээ тэнгэрээс халиаж байгаа буй заа. Ингэхэд, одоо манайхан нас барсан хүний "сүнс" гэж зөндөө ярьж бичих болж. Уг нь амьд хүнийхийг "сүнс", нас барсан хүнийхийг "зуурт" гэж ялгадаг. Монголоор "ᠵᠠᠭᠤᠷᠲᠤ" jaγuratu" гэж бичдэг. Жишээ болгож, Гучинзургаат тайлбар толиос эш татвал: "Үгүй болсон хүмүүний сүнсийг Зуурт хэмээмүй" (Г-10031) гэжээ.

## 02. Гарбичмэлийн эх



### Тайлбар

\*1 kelen-dü гэж байсныг сүүлд kelen-ber болгон засжээ. todurqayilaysan anu гэсэнгүй, todurqayilaysan inü гэжээ. Энэ хүртэл дөрвөн мөр, хөх бэхээр, тогтуун, шүдтэй бичсэн байна.

\*2 Эндээс гурван мөр, ногоон бэхээр, татлан-гүй бичсэн. Хожим нэмсэн бололтой.


### Галиг

- (1) Minu mongyol kelen-ber
- (2) orciyuluysan jüuil-ün
- (3) ner-e, on-i todurqayilaysan
- (4) inü
- (5) γaγca-kü neyitelegülügsen-i
- (6) duradbai; Činggikü-degen,
- (7) basa, qaraqan бүрin busu!

### Кирилл үсгийн сийрүүлэг

- (1) Миний монгол хэлээр \*1
- (2) орчуулсан зүйлийн
- (3) нэр, оныг тодорхойлсон
- (4) нь.
- (5) Гагцхүү нийтлүүлснийг
- (6) дурдвай; Чингэхдээн,
- (7) бас, хараахан бүрэн бус!


## Багштаны орчуулсан зохиолын нэр



\*1 Зарим бүртгэлд "Ертөнцийг дэнсэлгэн хөдөлгөсөн арав хоног" гэжээ.


- (1) *Jon Rid. Delekei-yi dengselgegsen arban edür.*
- (2) *Leninyrad-tur 1926 on-dur ekileged 1927 on-u*
- (3) *namur Ulayanbayatur-tu tegüsgegsen-i 1931 on-du*
- (4) *МОПОР-un Idamsürin keblen-e gejü aburyad, МОПОР-i*
- (5) *usadqaqu-du oldaqu-ban bayijuquii!*
- (6) *1926-27*

- (1) *Жон Рид. Дэлхийг дэнсэлгэсэн арван өдөр.\*1*
- (2) *Ленинградд 1926 онд эхлээд 1927 оны*
- (3) *намар Улаанбаатарт төгсгөснийг 1931 онд*
- (4) *МОПР-ын Ядамсүрэн хэвлэнэ гэж аваад, МОПР-ыг*
- (5) *устгахад олдохоон байжухуй!*
- (6) *1926-27*



- (1) *Türgenev.*
- (2) *Ürgüljilegsen üge-yin silüglel buyu*
- (3) *ötegüs-ün üge Senilia. Sin-e*
- (4) *toli-du γanča nige jüuil-i γaryaju, busud-i*
- (5) *küriyeleng-dü nuγulayan-u üyes, mön 1937-8*
- (6) *on-du ügei bolγajuquii:*
- (7) *1927*


- (1) *Тургенев.*
- (2) *Үргэлжилсэн үгийн шүлэглэл буюу*
- (3) *өтгөсийн үг Senilia. Шинэ*
- (4) *тольд ганц нэг зүйлийг гаргаж, бусдыг*
- (5) *Хүрээлэнд нугалааны үес, мөн 1937-8*
- (6) *онд үгүй болгожухуй:*
- (7) *1927*



\*1 Зарим бүртгэлд "Ялгуусан амрагийн дуу", "Ялгуусан амрагийн дуун" гэжээ.

- (1) *Türgenev. Ilayuysan amaray-un dayulal.*
- (2) *1927 on-u namur orčiγulju gүйицэгсэн-i*
- (3) *Sinjilekū uqayan-u küriyeleng 1937-8 on-du*
- (4) *ügei kijüküi!*
- (5) *1927*


- (1) *Тургенев. Ялгуусан амрагийн дуулал.\*1*
- (2) *1927 оны намар орчуулж гүйцээнийг*
- (3) *Шинжлэх ухааны хүрээлэн 1937-8 онд*
- (4) *үгүй хийжүхүй!*
- (5) *1927*



\*1 Зарим бүртгэлд "Мянга бөгөөд нэгэн шөнө" гэсэн буй.


- (1) *Mingy-a nigen söni-yin üliгер.*
- (2) *Mardrias-un franča orčiγuly-a-yi*
- (3) *oros bolγaysan keblel-eče terigün debter-i*
- (4) *orčiγuluyad, Aqademi kemekü keblel-eče*
- (5) *sin-e orčiγuly-a γarγaqu suruy-iyar joγsuju,*
- (6) *nom-un sang-du qadayalaysan-i uy oros eke*
- (7) *-yin arban kedün boti-yin qamtu 1937-8*
- (8) *on-u üyes aγ-a bolγajuqui!*
- (9) *1927*

- (1) *Мянга нэгэн шөнийн үлгэр.\*1*
- (2) *Мардриасын франц орчуулгыг*
- (3) *орос болгосон хэвлэлээс тэргүүн дэвтрийг*
- (4) *орчуулаад, Академи хэмээх хэвлэлээс*
- (5) *шинэ орчуулга гаргах сургаар зогсож,*
- (6) *номын санд хадгалуулсныг уг орос эх*
- (7) *ийн арван хэдэн ботийн хамт 1937-8*
- (8) *оны үес алга болгожүхүй!*
- (9) *1927*




- (1) *A. Neverov. Talq-a-bar bayan*
- (2) *Taškenta qota.*
- (3) *1931 on-u nuγulayan-u jil, latin*
- (4) *üsüg-ün jöblel-ün Lubsang abuyad ügei*
- (5) *kijüküi!*
- (6) *1928 on-du orčiγulju bile.*
- (7) *1928*

- (1) *А. Неверов. Талхаар баян*
- (2) *Ташкент хот.*
- (3) *1931оны нугалааны жил, латин*
- (4) *үсгийн зөвлөлийн Лувсан аваад үгүй*
- (5) *хийжүхүй!*
- (6) *1928 онд орчуулж билээ.*
- (7) *1928.*




- (1) *Jek London. Kis-iin domuγ.*
- (2) *Latin üsüg-ün jöblel-ün Qayangqirva abuyad.*
- (3) *jöblel usadqu-du sin-e ergilte-yin üyes*
- (4) *aγ-a boljuqui!*
- (5) *1928 on*

- (1) *Жек Лондон. Кишийн домог.*
- (2) *Латин үсгийн зөвлөлийн Хаянхярваа аваад.*
- (3) *зөөлөл устахад шинэ эргэлтийн үес*
- (4) *алга болжүхүй!*
- (5) *1928 он*




- (1) *A. Püskin.*
- (2) *Absačin. 1928 on-du орчиулуулан.*
- (3) *Ulus-un keblel-i 36 on-du байгуулууд,*
- (4) *37 on-du keblekü-iyer beledjü bayital-a,*
- (5) *tere üy-e-yin qauli jabqarayulγ-a-yin bujiginayan*
- (6) *-iyar aly-a boljuqui!*
- (7) 1929 он

- (1) *А. Пушкин.*
- (2) *Авсчин. 1928 онд орчуулсан.*
- (3) *Улсын хэвлэлийг 36 онд байгуулаад,*
- (4) *37 онд хэвлэхээр бэлдэж байтал,*
- (5) *тэр үеийн хууль завхруулгын бужигнаан*
- (6) *-аар алга болжухуй.*
- (7) 1929 он



- (1) *Sekspir. Maqbed*
- (2) *1929 on-du орчиулуулан. Нуулаулан-у үеес*
- (3) *Töb qorigan-u dörbed Badaraq, köringgeten-ü*
- (4) *joqiya-i keblekü ügei kemejükküi. Dayun uqayan-u*
- (5) *tasuy-tu bayısan inü, üregdejü, Peringlei,*
- (6) *1948 on-du ekin-u kedün tasurqai qayudasu*
- (7) *qoy dumda-aça olju öggügsen:*
- (8) 1929.


- (1) *Шекспир. Макбет.*
- (2) *1929 онд орчуулсан. Нугалааны үес*
- (3) *Төв хорооны дөрвөд Бадрах, хөрөнгөтний*
- (4) *зохиолыг хэвлэхгүй хэмээжухуй. Дуун ухааны*
- (5) *тасагт байсан нь, үрэгдэж, Пэринлэй,*
- (6) *1948 онд эхний хэдэн тасархай хуудас*
- (7) *хог дундаас олж өгсөн:*
- (8) 1929.



- (1) *Mingγ-a nigen söni-yin üliгер.*
- (2) *Aqademi-yin sin-e орчиулуула-бар*
- (3) *terigün debter-i орчиулжу гүйцээгед*
- (4) *нуулаулан-у үе-е-дү дөрвөд Badaraq-du*
- (5) *üjegüljü, keblekü jöbsiyerel yuyubasu,*
- (6) *fiodal-un üliгер, Allah tngri-tei yaγum-a*
- (7) *keblejü bolqu ügei kemegsen-dür urmas tasurçu*
- (8) *орчиулуула-бан ном-ун sang-du qadayalaysan bile.*
- (9) *1959 on-du üjeküle, 1945 on-du*
- (10) *байуулан орчиулуула-а мини үгеи болжууқи:*
- (11) 1929


- (1) *Мянга нэгэн шөнийн үлгэр.\*1*
- (2) *Академийн шинэ орчуулгаар*
- (3) *тэргүүн дэвтрийг орчуулж гүйцээд*
- (4) *нугалааны үед дөрвөд Бадархад*
- (5) *үзүүлж, хэвлэх зөвшөөрөл гуйваас,*
- (6) *феодалын үлгэр, Аллах тэнгэртэй юм*
- (7) *хэвлэж болохгүй хэмээсэнд урмас тасарч*
- (8) *орчуулгаа номын санд хадгалсан билээ.*
- (9) *1959 онд үзхүл, 1945 онд*
- (10) *байсан орчуулга минь үгүй болжухуй:*
- (11) 1929

\*1 Зарим бүртгэлд "Мянга бөгөөд нэгэн шөнө" гэсэн бий.




- (1) *Ya. Wasserman. Qahomalqa-yin alta.*  
(2) 1930 он-у ебүл орčiюлууһсан. Олан сөни ла-йин  
(3) *gerel-dü sayuju bir-iyer muutuu čaγasun-dur*  
(4) *bičigsen bile: Kūriyeleng-dü dayun uqayan-u tasuy-tu*  
(5) *bayıγsan inü 1937 он-у üyes aly-a boljuqui.*  
(6) 1930

- (1) **Я. Вассерман. Кахомалкийн алт.**  
(2) 1930 оны өвөл орчуулсан. Олон шөнө лааны  
(3) гэрэлд сууж бийрээр муутуу цаасанд  
(4) бичсэн билээ: Хүрээлэнд дуун ухааны тасагт  
(5) байсан нь 1937 оны үес алга болжухуй.  
(6) 1930




- (1) *Maqsim Gorki. Üliгер-ün učar.*  
(2) 1930 он-ду орčiюлууһсан биле: Mingγ-a nigen  
(3) *söni-yin qamtu γarγaqu gekü-dür Töb qoriyan-u*  
(4) *dörbed Badaraq, jöbsiyeregsen ügei. Gayčakü*  
(5) *sin-e ergilte-eče qoyisi, Badaraq-yi*  
(6) *qobquraysan qoyin-a Arab Armin-u üliгер-ün*  
(7) *tegübüri-yin ekin-dü keblegsen bile.*  
(8) 1930

- (1) **Максим Горький. Үлгэрийн учир.**  
(2) 1930 онд орчуулсан билээ: Мянга нэгэн  
(3) шөнийн хамт гаргах гэхэд Төв хорооны  
(4) дөрвөд Бадрах, зөвшөөрсөнгүй. Гагцхүү  
(5) шинэ эргэлтээс хойш, Бадрахыг  
(6) ховхорсон хойно Арав Армян үлгэрийн  
(7) түүврийн эхэнд хэвлэсэн билээ.  
(8) 1930



- (1) *Jek London. Niγuča-yin ejen.*  
(2) 1930 он-ду орčiюлууһад, dörbed Badaraq  
(3) *keblekü-yi jöbsiyeregsen ügei učar-ača Yangjim-a*  
(4) *daruy-a-tai ulus-un keblel-eče egegülün abču*  
(5) *kūriyeleng-dü qadayalaysan-i 1946 он-ду olbasu,*  
(6) *bögse-yi aldajuqui: dutayu-yi nökjü*  
(7) *orčiylqu urmas tasurjuqui:*  
(8) 1930


- (1) **Жек Лондон. Нууцын эзэн.**  
(2) 1930 онд орчуулаад, дөрвөд Бадрах  
(3) хэвлэхийг зөвшөөрсөнгүй учраас Янжмаа  
(4) даргатай улсын хэвлэлээс эгүүлэн авч  
(5) хүрээлэнд хадгалсныг 1946 онд олвоос,  
(6) бөгсийг алджухуй: дутууг нөхөж  
(7) орчуулах урмас тасаржухуй:  
(8) 1930



- (1) *Volt Vitmen. Ebesün-ü nabči.*  
(2) *Nacov, körünggeten-ü joqiyal orčiylju,*  
(3) *ajil süyidgejü bayin-a kemejü jimeleged,*  
(4) *keblekü yajar ese oldaysan-du dayun uqayan-u tasuy-tu*  
(5) *qadayalaysan-i 1942 он-у tabun sar-a-du erigülübesü*  
(6) *oldaysan ügei üregdejüküi:*  
(7) 1930

- (1) **Уолт Уитмен. Өвсний навч.**  
(2) Нацов, хөрөнгөтний зохиол орчуулж,

- (3) ажил сүйтгэж байна хэмээж зэмлээд,
- (4) хэвлэх газар эс олдсонд дуун ухааны тасагт
- (5) хадгалсныг 1942 оны таван сард эрүүлвээс
- (6) олдсонгүй үрэгджүүхүй:
- (7) 1930



\*1 дээд талд оросоор ийн бичжээ.

\*Заримдаа „Без заглавия” гэсэн буй.

\*2 М. Баянзулын бүртгэлд „Улсын номын санд хадгалагдаж буй” гэжээ.


(1) **Їеғов. Нег-е үгеи жүйл.**

- (2) 1930 он-ду орчйулжу, масин-а-бар
- (3) сейрегүлжү чоқиγсан-у ниге қуби-γи
- (4) Helsingki-dü Ramstedt-tur yabuyulju,
- (5) нөгүге қуби-γи күриγеленг-еҫе кеблекү үгеи кемегсен
- (6) tula dayun uqayan-u tasuy-tu qadayalayad,
- (7) 1942 он-у табун сар-а-ду (kilis kereg-iyer
- (8) 1937 он-ду šorong-du oruyсан-u qoyin-a,
- (9) ami бүтүн γарчу) erigülbesu еҫе oldajuqui:
- (10) 1930

Чехов. Без названия.\*1

(1) **Чехов. Нэргүй зүйл.**

- (2) 1930 онд орчуулж, машинаар
- (3) сийрүүлж цохисны нэг хувийг
- (4) Хелсинькид Рамстедтэд явуулж,
- (5) нөгөө хувийг хүрээлэнгээс хэвлэхгүй хэмээсэн
- (6) тул дуун ухааны тасагт хадгалаад,
- (7) 1942 оны таван сард (хилс хэргээр
- (8) 1937 онд шоронд орсны хойно,
- (9) амь бүтэн гарч) эрүүлвээс эс олджухуй:\*2
- (10) 1930



\*1 "хамт" гэдэг үгийн дараа "тэр хайрцагаас" гэдгийг оруулсан байна.

\*2 "Хэл бичиг сайжруулах бодолгын бичиг гэдэгт шинэ эргэлтээс хойш хэвлүүлсэн" гэдгийг цаасны дээд талд 9 мөр болгон жижгээр бичсэн байна.

Нидерландийн уран зохиолч Мультатулийн "Сайз" гэдэг зохиолоос. Монгол хэл бичгийг сайжруулах бодолгын өгүүлэл. 8-р дэвтэр. УБ. МХХ. 1935. 55 тал


(1) **Mültatuli. Sayija.**

- (2) 1931 он-ду орчйулурсан: ulus-un keblel-dü
- (3) байγсан ? (Bajarjab)-tu keblegülür-e
- (4) öggübesü, dörbed Badaraq-u üjegülüged, eyimü
- (5) "šai demei yayum-a" keblejü bolqu үгеи кемегсен:
- (6) 1932 он-ду тере ulus-un keblel-i usudqaqu-dur
- (7) qoy-un qayirčay dotur nilbuqu ged Sayija-γi
- (8) minu öggügsen Dekmeron-u nooray eke-γin
- (9) qamtu тере qayirčay-ača olju abuyсан bile.
- (10) Kele bičig
- (11) sayijirayulqu
- (12) bodulγ-a-γin
- (13) bičig
- (14) gedeg
- (15) -tur sin-e
- (16) ergilte-eҫe
- (17) qoyisi
- (18) keblegülügsen.
- (19) 1931

(1) **Мультатули. Сайз.**


- (2) 1931 онд орчуулсан: улсын хэвлэлд
- (3) байсан ? (Базарзав)-т хэвлүүлэхээр
- (4) өгөөс дөрвөд Бадархад үзүүлээд, ийм
- (5) "шал дэмий юм" хэвлэж болохгүй хэмээсэн:
- (6) 1932 онд тэр улсын хэвлэлийг устгахад
- (7) хогийн хайрцаг дотор нулмих гээд Сайзаг
- (8) миний өгсөн Декмероны ноорог эхийн
- (9) хамт тэр хайрцагаас\*1 олж авсан билээ.
- (10) Хэл бичиг
- (11) сайжруулах

- (12) бодолгын
- (13) бичиг
- (14) гэдэг
- (15) ~т шинэ
- (16) эргэлтээс
- (17) хойш
- (18) хэвлүүлсэн.\*2
- (19) 1931



- (1) **Natiman Narimanov. Пир.**
- (2) 1931 он-ду орчиулжу, жалаушуд-ун
- (3) sedkul-dü öggügsen-i 1936 он-аца kebleju
- (4) ekiltel-e, següi-i aldayuqui. Nadur daqin
- (5) nökün orçiyulqu joriy oldaysan ügei!
- (6) 1931


- (1) **Нариман Нариманов. Пир.**
- (2) 1931 онд орчуулж, залуучуудын
- (3) сэтгүүлд өгснийг 1936 оноос хэвлэж
- (4) эхлэтэл, сүүлийг алджухуй. Надад дахин
- (5) нөхөн орчуулах зориг олдсонгүй!
- (6) 1931



- (1) **Longfello. Hayawada. 1931 он-ду**
- (2) anggii-аца орчиу(л)уулан.
- (3) Ulus-un keblel-dür 1937 он-у бујигинауан
- (4) -iyar minu şügüi-eçe aly-a boluysan: Lodoi,
- (5) 1940 он күртел-е şügüi-dü байулан. qojim
- (6) yamun-u tölügelegçi abuysan gedeg.
- (7) 1931

- (1) **Лонфелло. Хайавада. 1931 онд**
- (2) англиас орчуу(л)сан.\*1
- (3) Улсын хэвлэлд 1937 оны бужигнаан
- (4) -аар миний шүүгээнээс алга болсон: Лодой
- (5) 1940 он хүртэл шүүгээнд байсан, хожим
- (6) яамны төлөөлөгч авсан гэдэг
- (7) 1031


\*1 „орчиулуулан, орчуулсан“ гэдэг үгийн „л“-ийн цацлагыг тавиагүй байна.



- (1) **Maqsim Gorki. Emeliyan Pilai**
- (2) 1934 он-ду орчиулууад, күрийеленг-үн
- (3) dayun uqayan-u tasuy-tu sin-e toli-dur
- (4) yaryaqu-bar beledjü bayıysan-i ulus-un
- (5) keblel-dü siljiged keblejü cidaysan ügei.
- (6) Ködegen-ü Peringlei, qoy dotur-аца
- (7) kedün qayudasu eki segül ügei orçiyulı-a-yı
- (8) olju öggügsen.
- (9) 1934

- (1) **Максим Горький. Емельян Пилай.**
- (2) 1934 онд орчуулаад, хүрээлэнгийн
- (3) дуун ухааны тасагт шинэ тольд
- (4) гаргахаар бэлдэж байсныг улсын
- (5) хэвлэлд шилжээд хэвлэж чадсангүй.
- (6) Хөдөөний Пэринлэй хог дотроос
- (7) хэдэн хуудас эх сүүлгүй орчуулгыг
- (8) олж өгсөн:
- (9) 1934






\*1 "Зарим зүйлд Алтан тархитай хүний домог" гэсэн буй.

- (1) *Alfongs Dode.*
- (2) *Altan tarqi-tu kümün.*
- (3) ..... есє бичгєсэн жагйя-а
- (4) *kemekü-yi orčiyulju байгйсан бөгөд,*
- (5) *sin-e toli-du ubun čubun neyitelekü*
- (6) *-ber ekilejü байгйсан: 1937 он-у*
- (7) *süйдkelgen-ü köl-iyer бүкү орčiyулурсан*
- (8) *jүйil үрегдежүкүй:*
- (9) 1935


- (1) *Альфонс Додэ.*
- (2) *Алтан тархит хүн.\*1*
- (3) ..... ээс бичсэн захиа
- (4) хэмээхийг орчуулж байсан бөгөөд,
- (5) шинэ тольд уваң цуван нийтлэх
- (6) -ээр эхлэж байсан: 1937 оны
- (7) сүйтгэлгээний хөлөөр бүх орчуулсан
- (8) зүйл үрэгджүхүй.\*1
- (9) 1935



\*1 "Үндэсний соёлын зам, дугаар 4, 1936 он"-ыг ногоон бэхээр, сүүлд нөхөж бичсэн бололтой. Мөхөс хүн, 1965 оны 11-р сарын 14-ний даваа гарагийн 10 цаг 33 минутанд энэ хүртэл хуулан бичжээ.


- (1) *Irland-un domuy. Köhülin-ü domuy.*
- (2) *Isidorji-du öгcү Gegeregülkü yamun-u*
- (3) *sedkül-dü 1935 он-du орčiyулурсан-u*
- (4) *daray-a öгcү keblegүлүgsen:*
- (5) *Aqademi gedeg jöbleltү-yin sayiqan keblel-ün*
- (6) *neyitelegsен бичиг-еcе mongyolčilaysан.*
- (7) *Üндүсүн-ү сойул-un jam, дугар 4,*
- (8) 1936 он.
- (9) 1935

- (1) *Ирландийн домог. Көхөлиний домог.*
- (2) *Ишдоржид өгч Гэгээрлийн яамны*
- (3) *сэтгүүлд 1935 онд орчуулсны*
- (4) *дараа өгч хэвлүүлсэн:*
- (5) *Академи гэдэг зөвлөлтийн сайхан хэвлэлийн*
- (6) *нийтэлсэн бичгээс монголчилсон.*
- (7) *Үндэсний соёлын зам, дугаар 4,*
- (8) 1936 он.\*1
- (9) 1935




- (1) *Морассан. Ебүген.*
- (2) *Sin-e toli. дугар 2.*
- (3) 1935.
- (4) 1935

- (1) *Морассан. Өвгөн.*
- (2) *Шинэ толь. дугаар 2.*
- (3) 1935.
- (4) 1935



- (1) *Морассан. Гар.*
- (2) *Sin-e toli. дугар 1. 1935 он*
- (3) 1935


- (1) *Морассан. Гар.*
- (2) *Шинэ толь. дугаар 7. 1935 он*
- (3) 1935



- (1) **А. Додэ.**
- (2) **Алтан тархитай<sup>\*1</sup> хүн**

<sup>\*1</sup> Үүний түрүү "Алтан тархит хун" гэсэн байсан. Багштан, энэ бүртгэлээ монгол худам үсэг, монгол кирилл үсгээр хосолж бичсэн.


- (1) **Altan tarqi-tai kümün.**
- (2) *Sin-e toli. duyar 2.*
- (3) *1935 on.*
- (4) *1935*



- (1) **Arab, Armen, Iran üliġer.**
- (2) *1935 on. Ulayanbayatur.<sup>\*1</sup>*
- (3) *... tal-a*
- (4) *1935*

- (1) **Араб, Армян, Иран үлгэр**
- (2) *1935 он. Улаанбаатар.<sup>\*1</sup>*
- (3) *... тал<sup>\*2</sup>*
- (4) *1935*


<sup>\*1</sup> "Улсын хэвлэл" гэж бичээд дарж, "Улаанбаатар" болгосон байна.  
<sup>\*2</sup> талын дугаарыг тавиагүй байна.



- (1) **Сэтэн Томпсон**
- (2) **Спрингфильдын үнэг**
- (3) *1935 он.<sup>\*1</sup> 23 тал х.<sup>\*2</sup>*
- (4) *1935*

<sup>\*1</sup> Багштан, энэ бүртгэлээ монгол худам үсэггүйгээр, зөвхөн монгол кирилл үсгээр, ногоон бэхээр бичсэн, зарим зүйлд "Сперинфельдын үнэг" гэсэн буй.

<sup>\*2</sup> Талыг, сүүлд хөх бэхээр нөхөж бичсэн байна.




- (1) **Максим Горький**
- (1) **Maqsim Gorqi.**
- (2) *Qan, qan köbegün qoyar.*
- (3) *Küriyeleng-ün keblel. 1936*
- (4) *22 tal-a*
- (5) *1935*

- (1) **Максим Горький<sup>\*1</sup>**
- (1) **Максим Горький**
- (2) **Хан, хан хөвүүн хоёр.**
- (3) *Хүрээлэнгийн хэвлэл. 1936*
- (4) *22 тал.*
- (5) *1935<sup>\*2</sup>*

<sup>\*1</sup> Багштан, энэ бүртгэлээ монгол худам үсэг, монгол кирилл үсгээр хосолж бичсэн.

<sup>\*2</sup> 1936 гэж байсныг хөх бэхээр сүүлд "1935" болгож зассан. Ер нь, эхлээд хуудасны дугаарыг цэглэж орхиод дараа нь нөхөж бичсэн юм байна. Зарим газар онгоорхой i орхисон нь хожим нөхөх учиртай байж.



\*1 Зарим зүйлд "Сонгогчдод ухуулах захидлаас орчуулсан нь" гэсэн буй.


- (1) *Mültatuli*
- (2) Сайја.
- (3) *Medegsen-iyer dayu bay-a ügei ajam.*
- (4) *Gesigüü tegükü cibayanca.*
- (5) *Songyuücid-tur uqayulqu jaqidal.*
- (6) *Siduryu toytayal*
- (7) *Kele biçig sayjirayulqu boduly-a-yin*
- (8) *8 duyar debter.*
- (9) 1935

- (1) *Мультатули.*
- (2) Сайз.
- (3) Мэдсэнээр дуу багагүй ажам.
- (4) Гишүү түүх чавганц.
- (5) Сонгогчдод ухуулах захидал.\*1
- (6) Шударга тогтоол
- (7) Хэл бичиг сайжруулах бодлогын
- (8) 8 дугаар дэвтэр.
- (9) 1935




- (1) *Mingy-a nigen söni kemekü arab-un üliгер-еёе*
- (2) *орчиулурсан нирүү үгеи күмүн-ү йисүн*
- (3) *bölüg üliгер.*
- (4) *Küriyeleng-ün dayun uqayan-u tasuy-un*
- (5) *keblel.*
- (6) *69 тал хуудас*
- (7) 1935

- (1) *Мянга нэгэн шөнө хэмээх арабын үлгэрээс*
- (2) *орчуулсан нуруугүй хүний есөн*
- (3) *бөлөг үлгэр.*
- (4) *Хүрээлэнгийн дуун ухааны тасгийн*
- (5) *хэвлэл.*
- (6) *69 тал хуудас*
- (7) 1935





- (1) *Максим Горький*
- (2) *Салхич шувуу*
- (1) *Maqsim Gorqi*
- (2) *Salqici sibayu*
- (3) *Qan, qan köbegün-ü qamtu*
- (4) *22 tal-a.*
- (5) 1935

- (1) *Максим Горький*
- (2) *Салхич шувуу*
- (1) *Максим Горький*
- (2) *Салхич шувуу*
- (3) *Хан, хан хөвүүний хамт*
- (4) *22 тал.*
- (5) 1935




- (1) *Барбюсс Анри*
- (2) 1936 он.
- (1) *Barbusse Hanri.*
- (2) *Jiluyu bariüci kümün.*
- (3) *Küriyeleng-ün keblel tusqai*
- (4) *debter.*
- (5) *Qojim kedün uday-a*
- (6) *sedkül-üd-tür yarjuqi.*
- (7) 1936

\*1 Багштан өөрөө, *күйн* гэдэг үгийг "хүн", "хүмүүн" гэж шинэ үсгээр буулгасныг дагаж. Жишээлбэл: "Алтан тархит хүн", "Жолоо баригч хүмүүн" гэжээ.



\*1 Багштан энд зохиогчийн нэрийг тавьсангүй. Өөр нэг бүртгэлдээ "Перельман. Пуужингаар сарнаа нисмой" гэсэн буй.



\*1 Багштан энэ бүртгэлээ монгол худам үсэг, монгол кирилл үсгээр хосолж бичсэн. Баруун дээд талд

"Нугалаанаас өмнө орчуулсан болай" гэж ногоон бэхээр үг бүрийг мөр болгон бичжээ.

(1) **Барбюсс Анри.**  
(2) 1936 он.

(1) **Барбюсс Анри.**  
(2) **Жолоо баригч хүмүүн.**\*1  
(3) Хүрээлэнгийн хэвлэл Тусгай  
(4) дэвтэр.  
(5) Хожим хэдэн удаа  
(6) сэтгүүлүүдэд гаржухуй.  
(7) 1936

(1) **A. Püskin.**  
(2) Тариачин абагай.  
(3) *Ulus-un keblel.*  
(4) 1936

(1) **А Лушкин.**  
(2) Тариачин авхай  
(3) Улсын хэвлэл.  
(4) 1936

(1) **Puujin-iyar saran-a nisümüi.**\*1  
(2) *Ulus-un keblel. Ulayanbayatur.*  
(3) *tal-a.* 1936 он  
(4) 1936

(1) **Пуужингаар сарнаа нисмүй.**  
(2) Улсын хэвлэл. Улаанбаатар.  
(3) *тал.* 1936 он  
(4) 1936

(1) *Nuyulayan-ača*  
(2) *emün-e*  
(3) *orcüyuluysan*  
(4) *bolai*\*1

(1) **Türgenev. Teneg.**  
(2) *Sin-e toli, duryar 5-6*  
(3) 1936

(1) **Тургенев. Тэнэг.**  
(2) *Шинэ толь. дугаар 5-6*  
(3) 1936 он  
(4) 1936

... Үргэлжлэл буй